

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

**1/45<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“45<sup>1</sup> дүгээр зүйл. Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татах асуудлыг хэлэлцэх журам**

45<sup>1</sup>.1. Доор дурдсан тохиолдолд 7 хоногийн дотор Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татах асуудлыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана:

45<sup>1</sup>.1.1. гишүүн өөр ажилд шилжих болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан;

45<sup>1</sup>.1.2. гишүүн хүндээр өвчилсний улмаас цаашид бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гаргасан;

45<sup>1</sup>.1.3. Үндсэн хуулийн цэц гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан;

45<sup>1</sup>.1.4. гишүүн гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдаж, шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон;

45<sup>1</sup>.1.5. гишүүний сонгогдсон тойргийн сүүлийн сонгуульд оролцсон нийт сонгогчдын гуравны нэгээс доошгүй нь гишүүнийг эгүүлэн татах санал гаргасан.

45<sup>1</sup>.2. Нэгдсэн хуралдаан гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татах асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооны энэ хуулийн 45<sup>1</sup>.1.1, 45<sup>1</sup>.1.2, 45<sup>1</sup>.1.3, 45<sup>1</sup>.1.4-т заасны дагуу гаргасан санал, дүгнэлтийг сонсож, ил санал хураалт явуулах бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх чөлөөлөх, эгүүлэн татах саналыг дэмжсэн бол энэ тухай тогтоол батлагдсанд тооцно.

45<sup>1</sup>.3. Энэ хуулийн 45<sup>1</sup>.1.5-д заасны дагуу гаргасан саналыг Төрийн байгуулалтын байнгын хороо болон Нэгдсэн хуралдаанд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга уншиж танилцуулснаар эгүүлэн татах тухай тогтоол батлагдсанд тооцно.

45<sup>1</sup>.4. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асууж, үг хэлж болно.

45<sup>1</sup>.5.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд энэ хуулийн 45<sup>1</sup>.1-д заасан асуудлыг хэлэлцэх, уншиж танилцуулахад холбогдох албан тушаалтан, иргэдийн төлөөлөл оролцож гишүүдийн асуултад хариулт өгч болно.

45<sup>1</sup>.6.Төрийн байгуулалтын байнгын хороо шаардлагатай гэж үзвэл гишүүнийг эгүүлэн татах санал гаргасан сонгуулийн эрх бүхий иргэдийн гарын үсгийн үнэн зөв байдал болон санал гаргасан иргэн нь тухайн тойрогт харъяалагдах засаг захиргааны нэгжид байнгын оршин суугч мөн эсэх талаарх лавлагаа гаргуулахаар сонгуулийн төв байгууллагад хүсэлт гаргаж болно.

45<sup>1</sup>.7.Энэ хуулийн 45<sup>1</sup>.6-д заасан асуудлаар сонгуулийн төв байгууллагаас лавлагаа гаргаж ирүүлсэн бол 7 хоногийн дотор Төрийн байгуулалтын байнгын хороо гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татах асуудлыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

45<sup>1</sup>.8.Энэ хуулийн 45<sup>1</sup>.1.5-д заасны дагуу гишүүнийг эгүүлэн татах санал гаргах сонгогч нь сүүлийн сонгуулиар тухайн сонгуулийн тойрог дахь сонгогчдын нэрийн жагсаалтад нэр нь бичигдсэн сонгуулийн эрх бүхий иргэн байна.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.6.7 дахь заалт нэмсүгэй:

“6.6.7. гишүүнийг сонгогчдын саналаар эгүүлэн татах асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооны гаргасан дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд уншиж танилцуулсан.”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийн “6.6.6” гэсний дараа “, 6.6.7” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/7 дугаар зүйлийн 7.8, 7.9 дэх хэсэг:**

“7.8.Хороо нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45<sup>1.6</sup>-д заасны дагуу гаргасан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 60-аас дээшгүй хоногт багтаан, гишүүнийг эгүүлэн татах санал гаргасан сонгуулийн эрх бүхий иргэдийн гарын үсгийн үнэн зөв байдал, санал гаргасан иргэдийн засаг захиргааны нэгжид байнгын оршин суугч мөн эсэх талаарх лавлагааг гаргана.

7.9.Хороо энэ хуулийн 7.8-д заасны дагуу лавлагаа гаргахад хамгийн сүүлийн Улсын Их Хурлын сонгуулийн тухайн тойргийн ирц, сонгогчдын нэрийн жагсаалтыг эх сурвалж болгоно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг